## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ УДИРДЛАГА

**П.Цэдэв** - *доктор* **(PhD)**
**Ж.Дамбадаржаа** *-ДХИС-ийн Удирдлагын академийн 8062-р дамжааны суралцагч*

# ГАМШГИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛ

## Оршил

Дэлхий нийтийг хамран тархсан коронавируст халдвар (Covid-19)-т цар тахалтай тэмцэх арга хэмжээ нь дан ганц УОК, ОБЕГ, ЭМЯ-ны ажил биш, төрийн болон төрийн бус болоод аж ахуйн нэгж байгууллагын хүч чармайлт хэрэгтэй болох харагдаж байна.

Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайд С.Энхболдын хэлснээр иргэдийн дэмжлэг, хамтын ажиллагаагүйгээр бид энэ цар тахлыг давж гарахгүй" гэсэн бол МУ-ын Шадар сайд, УОК-ийн дарга С.Амарсайхан "манай улсын эрүүл мэндийн тогтолцоо ямар хэмжээнд яаж явсан, хууль дүрмийнх нь үйлчлэл, харилцан уялдаа холбоо нөхцөл байдал нь ямар түвшинд хөгжсөн юм гэдгээ эргээд харах хэрэгтэй" байна гэсэн нь нь харилцан ажиллагаа чухал асуудал болж байгааг харуулж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш "Улс орнууд илүү сайн ойлголцож, бие биенээ харилцан дэмжиж, хамтарч ажиллахгүй бол наад захын хүндрэл, бэрхшээлд өвдөг сөхрөх сургамжийг өнгөрсөн хоёр жил авлаа. Тиймээс тодорхой ажлаа ярьж, саналаа солилцон, байгаа боломжоо дээд зэргээр ашиглаж байж цар тахал болон байгалийн гамшгийг даван туулах ёстой" гэж хэлсэн билээ. Энэхүү өгүүлэлдээ гамшгийн үеийн харилцан ажиллагааны үндсэн ойлголт, мөн чанар, удирдлагын хэлбэрийн талаар авч үзнэ.

## Үндсэн хэсэг

Ертөнцөд харилцан үйлчилдэггүй юм гэж ерөөсөө алга байна. Аливаа ажлыг амжилттай гүйцэхэд харилцан ажиллагаа маш чухал болжээ.

Хүний нийгмийн харилцаа бол харилцан ажиллагаа нь дээр оршиж, түүнд суурилагдаж байна.

Харилцан ажиллагаа гэдгийг эрдэмтэн, судлаачид олон янзаар тайлбарласан байна. Харилцан ажиллагааны талаар орос, англи хэл дээр тэр тусмаа цэргийн нэр томьёоны тольд нэлээд тодорхойлолт байна.

"Харилцан ажиллагаагүйгээр ялалт байхгүй " гэж үзсэн байна. Харилцан ажиллагаа нь хоёр болон түүнээс олон хэсэг, бүлэг субьектын хооронд явагддаг бөгөөд тэдний хоорондох нарийн түвэгтэй, ээдрээтэй асуудлыг шийдэх, нэгдсэн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд

чиглэгдэж байна. “Харилцан ойлголцох ба харилцан бие биендээ туслах нь хамгийн сайн тактик мөн" гэж Оросын тэнгисийн цэргийн адмирал П.С.Нахимов үзжээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, менежмент нь салбарын болон салбар хоорондын, холбогдох байгууллагууд хоорондын үйл ажиллагааг бүх түвшинд уялдуулан зохицуулах механизмаас хамаарах бөгөөд үндэсний, орон нутгийн түвшинд хууль тогтоох болон төрийн гүйцэтгэх бүх байгууллагуудын бүрэн оролцоог хангах, бизнесийн, шинжлэх ухааны байгууллагууд, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах, тэдний харилцан ажиллах, түншлэх, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх ёстой гэж тодорхойлсон байна. Мөн түншлэл нь улс орны нөөц бололцоог бүрэн ашиглах, гамшгийн эрсдэлийн менежментийн үндэсний чадавхийг сайжруулах, иргэд, олон нийт, улс орны нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн сайн сайхан аж байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг . Түншлэл гэдэг нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл эсвэл хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн оролцогч талцуудын хоорондын зөвшилцөл, тэгш эрх, ил тод байдал болон харилцан туслалцаа дэмжлэг, хүч эрмэлзэл, нөөц бололцоогоо дайчилахыг тодорхойлсон суурь харилцаа юм, Гамшгийн эрсдэлийг бууруулахад Онцгой байдлын алба, төрийн яам, гамшгаас хамгаалах Улсын алба /ГХУА/, агентлагуудын түншлэл хамтын ажиллагааг боловсронгуй болгох гэжээ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үндсэн удирдлагад “Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хүч оролцоог уялдуулан зохицуулах” гэж заасан байна.

Харилцан ажиллагаа жигдрээд ирэхээр хөгжил, дэвшил нь хурдасна. Тэгэхээр Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах Улсын албад, төв орон нутгийн байгууллагуудын харилцан ажиллагааны мөн чанар нь харилцан ажиллагааны үрээр тэдний хооронд оршиж буй үл ойлголцсон асуудлыг шийдвэрлэх, нэгдсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж бий болно.

ОХУ-ын Онцгой байдлын нэр томьёоны толь бичигт “Харилцан ажиллагаа” -г үүрэгтээ зорилгодоо хүрэхийн тулд цэргийн үйл ажиллагаа ба хүч хэрэгслийг үүрэг даалгаврыг биелүүлэх арга замууд ба зорилго, зорилт, газар орон, цаг хугацаатай уялдуулсан байдал гэжээ.

Дээрх байдлаас үзэхэд харилцан ажиллагаа гэдэг нь гамшигтай тэмцэх, аврах зорилгодоо хүрэхэд тавигдсан үүргийг биелүүлэхээр үүрэг, бодлого, чиглэл, газар орон, зааг, цаг хугацаа, аргуудаараа зохицуулагдсан аврах (хүч)-ийн ажиллагааг хэлэх бөгөөд Онцгой байдлын анги, салбаруудын хооронд гамшигтай тэмцэхэд тавигдсан үүрэг, зорилгыг биелүүлэх, хүч хэрэгсэл, төрөл

бүрийн аврах багаж, техникийн уялдуулан зохицуулсан дээд, дунд, үйл ажиллагааны түвшний нэгдэл хамтын ажиллагаа юм.

Харилцан ажиллагааг зохион байгуулах нь захирагч, даргын оюуны хөдөлмөр юм. Улсын онцгой комисс нь Онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах улсын албад, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулах үйл явц мөн.

ОББ, гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн албад, төв, орон нутгийн байгууллагын харилцан ажиллагааг түүнд оролцогч, зохион байгуулагчийн хэмжээ далайцаас бүрэлдэхүүний байдлаас хамаарч удирдлагыг дээд (стратег), дунд (опертив), үйл ажиллагаа (тактик)- ны гэж гурван түвшин -д хуваан үзнэ.

Дээд шатны удирдлагын харилцан ажиллагааг Монгол Улсын Шадар сайд, УОК, ОБЕГ, Улсын албадын хэмжээнд хамтран зохион байгуулна. Энэ нь гол төлөв ажиллагааны гэхээсээ илүүтэй дүрэм, журам, заавар, урьдчилсан төлөвлөлтийг боловсруулснаар явагдана.

Дунд шатны удирдлагын харилцан ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комисс, ОБЕГ-ын газар, хэлтэс, Төв, орон нутгийн ОБГ, хэлтэс, аврах бригад, аврах анги, ЗХЖШ, ХЦЕГ-ын тусгай мэргэжлийн ангиудын хооронд зохион байгуулна. Энэ үеийн ажиллагаа нь гол төлөв шуурхай шинж чанартай байна.

“Харилцан ажиллагааг зохицуулах ажлыг гамшгийн оперативын удирдлагын төв сайн хангаж чаддаг. Яагаад гэвэл гамшигтай тэмцэх ажлыг мэдээллээр хангах, зөв шийдвэр гаргахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг”. Үүнээс гадна гамшиг, осол, сүйрэлтэй тэмцэх ажлыг зохион байгуулах ОБЕГ-ын удирдлагын штаб, ГХУА, төв, орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах, ажил үүргийг хуваарилахтай холбогдсон бүх асуудлыг зохицуулах үүрэг гүйцэтгэнэ.

Үйл ажиллагааны удирдлагын харилцан ажиллагааг томилгоот төрөл бүрийн шуурхай бүлэг, аврах салаа, жижиг бүлгүүдийн хооронд зохион байгуулах бөгөөд гол төлөв хүний амь аврах, тусламж үзүүлэх ажиллагааны шинж чанартай байна.Эндээс харахад харилцан ажиллагааны дээрх хэлбэр нь удирдлага, оролцогч бүрэлдэхүүнээс хамааралтай болох нь илэрхий байна.

Харилцан ажиллагааны “тулгын гурван чулуу” загварыг тус бүрт үзье.

Нэгдүгээр хэлбэр - “мэдээллийн загвар”- энэ нь харилцан ажиллагч захирагч нар "адил эрхтэйгээр" харьцах бөгөөд тэдгээр нь хоорондоо сонирхож байгаа асуудлуудаараа мэдээлэл солицон, өөрийн үйл ажиллагаанд биеэ даан шийдвэр гаргаж тэдгээрийн ажиллагааг зохицуулах байдалтайгаар гүйцэтгэнэ.

Хоёрдугаар хэлбэр - "зөвшилцөх загвар" - энэ нь харилцан ажиллагч захирагч нар зөвхөн мэдээлэл солилцоод зогсохгүй өөрийн ашиг сонирхолд

ямар нэгэн үйл ажиллагаа явуулах талаар хүсэлтээ илэрхийлэх /заавар өгөхгүйгээр/ буюу түүнчлэн хамтарсан арга хэмжээний төлөвлөгөөний санал гаргаж болно. Энэ хувилбарыг хэрэглэснээр хамтын ажиллагаа нь ерөнхий шийдэлд хүрэх бөгөөд харилцан ажиллагч захирагч нарын захирагдсан байгууллага, анги, гамшгаас хамгаалах Улсын албадын хүчний ажиллагаа зохицуулагдсан, эмх цэгцтэй, ахлах дарга нарын ямар ч оролцоогүйгээр явагдах боломжтой байна.

Гуравдугаар хэлбэр - нэлээд хатуу, "тушаах загвар" - энэ нь харилцан ажиллагч дарга /захирагч/ нарын нэг нь ахлах даргын бүрэн эрхийн хэмжээнд шийдвэр гаргаж, тодорхой асуудлуудаар заавар өгөх бөгөөд энэ зааврыг тодорхой хүрээнд биелүүлнэ. Тухайлбал, гоц халдварт өвчинтэй тэмцэх, хорио цээр тогтоох үед шуурхай бүлэг, анги, салбаруудын хоорондох хэлхээг хэн хариуцаж, хэрхэн ажиллахад түүнчлэн дэмжигч хүч хэрэгслүүдтэй харилцан ажиллагааг зохион байгуулна.

Харилцан ажиллагааг зохион байгуулахад тухайн цагийн байдал болон гүйцэтгэх үүргийн шинж чанараас шалтгаалан дээр дурьдсан загваруудын аль нэгийг сонгон авна. Хамгийн ерөнхий байдлаар ойлгоход харилцан ажиллагааг зохион байгуулах гэдэг нь өөрийгөө удирдах ажлыг /нарийн тогтоосон хязгаалалттайгаар/ зохион байгуулах, өөрөөр хэлбэл хүний амь насыг аврах, гамшигтай тэмцэх ажиллагааг эмх цэгцтэй, зохицуулагдсан байдалтай болгох зорилгоор зарим үүргүүдийг хамтран биелүүлэх үед нэг нь нөгөөгийнхөө ажиллагааг удирдана гэж ойлгож болно.

Харилцан ажиллагааг ахлах дарга зохион байгуулна. Гэхдээ хүний амь насыг аврах, гамшигтай тэмцэх ажиллагааны туршлагаас үзэхэд харилцан ажиллагааг санаачилга гаргах журмаар зохион байгуулж байсан жишээ багагүй байдаг.

Тодорхой цагийн байдалд ахлах даргын оролцоог хүлээлгүйгээр харилцан ажиллагааг зохицуулах чадвартай, өндөр түвшинд бэлтгэгдсэн дарга (захирагч)-ийн удирдлагын байгууллагууд олон байдаг.

Системийн судалгааны байр сууринаас үзэхэд өөрөө зохион байгуулах чадвар нь чухал ач холбогдолтой байх болно. Ямар ч төрлийн гамшиг ялангуяа хүн, малын гоц халдварт өвчний тархалтын үед харилцан ажиллагааг зохион байгуулахадаа эрсдэлийн үнэлгээг хийсний дараагаар зохион байгуулж болно.

Харилцан ажиллагааг зохион байгуулах ажлын үндэс нь төлөвлөлт байна. Үүрэг нь хэдий чинээ нарийн төвөгтэй байна, түүнийг биелүүлэхэд төдий чинээ олон төрлийн аврах (хүч хэрэгсэл) оролцдог ба харилцан ажиллагааны төлөвлөгөө болон бусад баримт бичгүүдийг боловсруулах болно. Үүнээс гадна, тэдгээрийг боловсруулах, оролцуулахад цаг хугацаа зардаг боловч эдгээр баримт бичгийн дагуу хүний амь насыг аврах, хүч

хэрэгслийг удирдахад хүндрэлтэй нөхцөл байдал тохиолддог. Ийм учраас харилцан ажиллагааны баримт бичгүүдийг хялбаршуулж, ойлгоход дөхөм болгох, ингэснээрээ тэдгээрийг боловсруулахад зарцуулах хугацааг багасгах нь чухал болно. Тэгэхдээ, хүний амь насыг аврах үйл ажиллагааны явагдах бүхий л хугацаанд тасралтгүй харилцан ажиллагааг хангах болон өөрийн аврах үйл ажиллагааг эмх замбараагүй болгохоос хамгаалсан арга хэмжээнүүдийг урьдчилан бэлтгэх нь онцгой чухал ач холбогдолтой байна. Ийм бэлтгэлийг хийхэд, команд штабын дадлага сургууль, удирдах бүрэлдэхүүний хүрээнд явуулах зэрэг харилцан ажиллагааг зохион байгуулах төрөл бүрийн аргуудыг хэрэглэж болно. Эдгээрийн гол зорилго нь, бүх хүч хэрэгслийн хүний амь насыг аврах үүрэг гүйцэтгэх явцад гарч болох янз бүрийн цагийн байдлын үеийн үйл ажиллагааг нарийвчлан зөвшилдөж, санаа нэгдэн зохицуулах явдал юм.

Үүрэг даалгаврыг хамтран гүйцэтгэж байгаа шуурхай штаб нь цагийн байдал болон бусад нөхцөл байдлын талаар аль аль тал нь тодорхой мэдлэгтэй байх нь ОБА, гамшгаас хамгаалах Улсын албадын хамтын ажиллагааны амжилтад шууд нөлөөлдөг. Тэгэхдээ энэ мэдлэг нь зөвхөн яг өрнөж байгаа үйл ажиллагаанд хамаараад зогсохгүй, бас аврах (хүч хэрэгсэл)-ийн төлөвлөгдөж байгаа үйл ажиллагаанд ч хамаарна. Дарга (захирагч), өөрийнх нь эрх ашгийн тулд зохион байгуулагдаж байгаа харилцан ажиллагааны үед, гагцхүү шаардлагатай бүх мэдээллээр хангагдсан үед л зөв шийдвэр гаргаж чадна.

Харилцан ажиллагаа нь нэг бодлого, төлөвлөгөөний дагуу хийгддэг арга хэмжээнүүдийн цогцолбор байдаг тул, үр дүнг дээшлүүлэх зорилгоор дарга (захирагч), тэдний штабууд харилцан ажиллагаанд оролцож буй хүч хэрэгслийн боломж, хэрэглэх аргыг сайн мэддэг, орчин үеийн аврах үйл ажиллагааны мөн чанарыг сайн ойлгосон, өөрийн анги, салбарын үйл ажиллагааг практик дээр нарийн тодорхой зохицуулж чаддаг байх нь маш чухал юм.

## Дүгнэлт

Гамшигтай тэмцэхэд тэмцэх, аврах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх хамгийн оновчтой хэлбэрийн нэг бол үйл ажиллагааны /тактик/-ийн түвшингөөс эхлээд дээд /стратег/-ийн түвшинг хүртлэх бүхий л үе шатанд Онцгой байдлын албаны харилцан ажиллагаа чухал ач холбогдолтой.

## Санал

Гамшигтай тэмцэхэд УОК, ОБЕГ, гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн албад, ОБГ, хэлтэс, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хооронд харилцан ажиллах онол, аргазүй, практикийг гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгах ажилд өргөн нэвтрүүлэх;

УОК, ОББ, гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн албад, төв,

орон нутгийн байгууллагын харилцан ажиллагааг түүнд оролцогч, зохион байгуулагчийн хэмжээ, бүрэлдэхүүний байдлаас хамаарч удирдлагыг дээд, дунд, үйл ажиллагааны гэсэн гэж гурван түвшинд хуваан үзэх бөгөөд харилцан ажиллагааны удирдлагын гурван хэлбрийг ашиглах зэрэг болно.

**Эх сурвалжийн жагсаалт**


1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ, УБ., 2015.
2. Дашзэвэг.Ц нар, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014
3. Түмэн Б, Цэргийн урлагт гарч буй өөрчлөлт, УБ., 2010
4. Цэдэв П, Цэргийн харилцан ажиллагааны онол арга зүйн үндэс, УБ., 2021